



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 110

Булган

Уралдаан зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Дэлхийн усны өдөр"-ийг угтаж ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах "Цэнхэр сувд" уралдааны удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх уралдааныг чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т үүрэг болгосугай.
3. Үйл ажиллагаанд шаардагдах 1 830 000 /нэг сая найман зуун гуч/ төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын "Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа, эко уралдаан зохион байгуулах" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч Б.Очирсүрэнд зөвшөөрсүгэй.



З.БАТЗОРИГ

**“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГА, ДУНД, АХЛАХ АНГИЙН
СУРАГЧДЫН ДУНД “ЦЭНХЭР СУВД” УРАЛДААН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Зорилго: Монгол улс газар нутгийн байршлаараа усны гурван том хагалбарын заагт харьцангуй өндөрлөг, Ази-Номхон далайн бүс нутгийн хамгийн хур тунадас багатай, хуурайшилт ихтэй хэсэгт оршдог, усны нөөц нь нутаг дэвсгэрийн хувьд жигд бус тархалттай, зарим бүсийн усны чанар эрүүл ахуйн шаардлага хангадаггүйгээс гадны гол мөрний ус нь ихэнхдээ тус улсын хилээс гадагшаа урсдагаас шалтгаалан усны нөөцөөр бага, хязгаарлагдмал орны тоонд ордог. Тиймээс “Дэлхийн усны өдөр”-ийг угтан хүүхдийн нүдээр ус хэр үнэ цэнтэй байгааг мэдэх, тэдний бүтээлээр дамжуулан бусдад түгээх зорилгоор зохион байгуулна.

Хамрах хүрээ: Булган сумын ЕБС-иудын бага, дунд, ахлах бүлгийн сурагчид.

Хугацаа: 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2 дугаар сарын 17-ны өдөр хүртэл

Зохион байгуулагч: Булган аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар,
M20 залуучуудын клуб

Хамтран ажиллах байгууллага: Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар,
Залуучуудын хөгжлийн төв, Lead Mongolia “Хэрэглээ, хэмнэе, хамгаалъя” төсөл

Уралдааны болзол: Сэдвийн нэр - “Цэнхэр сувд - Усны үнэ цэнэ”

- Бага бүлгийн сурагчид сэдэвчилсэн зураг зурна.
- Дунд бүлгийн сурагчид багаар оролцож бүтээл хийнэ. Баг 5 гишүүнтэй байна.
- Ахлах бүлгийн сурагчид эссэ бичиж, илтгэл тавина.

Шагнал урамшуулал:

Бага бүлгийн сурагчид:

1-р байр, өргөмжлөл, 100 000 төгрөг

2-р байр, өргөмжлөл, 80 000 төгрөг

3-р байр, өргөмжлөл, 60 000 төгрөг

Дунд бүлгийн сурагчид /багаар/:

1-р байр, өргөмжлөл, 450 000 төгрөг

2-р байр, өргөмжлөл, 350 000 төгрөг

3-р байр, өргөмжлөл, 250 000 төгрөг

Ахлах бүлгийн сурагчид:

1-р байр, өргөмжлөл, 180 000 төгрөг

2-р байр, өргөмжлөл, 140 000 төгрөг

3-р байр, өргөмжлөл, 100 000 төгрөг

Холбоо барих: Залуучуудын хөгжлийн төв: 7034-2552

Б.Оюунболд /91916122/

Ч.Нарантуяа /89773445/

Аймгийн Засаг даргын 2020 оны дүгээр
..... сарын –ний өдрийн дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГА, ДУНД, АХЛАХ АНГИЙН
ХҮҮХДҮҮДИЙН ДУНД “ЦЭНХЭР СУВД” УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДАЛ**

Д/Д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Бага бүлгийн сурагчид				
1.	1-р байр	100 000	1	100 000
2.	2-р байр	80 000	1	80 000
3.	3-р байр	60 000	1	60 000
Дунд бүлгийн сурагчид /Багт 5 гишүүн/				
4.	1-р байр	450 000	1	450 000
5.	2-р байр	350 000	1	350 000
6.	3-р байр	250 000	1	250 000
Ахлах бүлгийн сурагчид				
7.	1-р байр	180 000	1	180 000
8.	2-р байр	140 000	1	140 000
9.	3-р байр	100 000	1	100 000
Бусад хэрэглэгдэхүүн				
10.	Өргөмжлөл	3 500	21	73 500
11.	Өргөмжлөлийн хавтас	1 500	21	31 500
12.	Бичиг хэрэг	15 000	1	15 000
Нийт				1 830 000